



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/Ч/10


Сүхбаатар сум

Алтанбулаг сумын төрийн өмчийн 3 дугаар
цэцэрлэгт тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.“а”, “Аж ахуй үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 23 дугаар зүйлийн 23.1, 30 дугаар зүйлийн 30.1.6, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 353 дугаар тушаалаар батлагдсан “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлага”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Алтанбулаг сумын Бүргэдэй 1 дүгээр багт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 50 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг шинээр ашиглалтад орсонтой холбогдуулан тус суманд төрийн өмчийн 3 дугаар цэцэрлэгийг шинээр байгуулж, сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай олгосугай.
2. Алтанбулаг сумын төрийн өмчийн 3 дугаар цэцэрлэгийг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгохыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга /Б.Саранчимэг/-т үүрэг болгосугай.
3. Алтанбулаг сумын төрийн өмчийн 3 дугаар цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Энхбат/, Боловсрол, соёл урлагийн газрын дарга /Ч.Жаргалсайхан/, Алтанбулаг сумын Засаг дарга /П.Батсайхан/ нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

Alban bichig Zahiramj